

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-Д
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН САНАЛЫН ТОВЬЁГ**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу хууль санаачлагчаас Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох материалын хамтаар Монгол Улсын Засгийн газарт 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-03/7012 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

Түүнчлэн хуулийн төсөлд олон нийтийн саналыг авах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6.4 дэх заалтын дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөсний дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан болон үр нөлөө, зардлын тооцооны тайлангийн хамт D-Parliament.mn цахим системд 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байршуулсан.

D-Parliament.mn цахим системд байршуулсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 221 хүн үзэж танилцсан байна.

№	Хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт	Хандалтын тоо	Саналын агуулга
	38 дугаар зүйлийн 38.6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тавин хувь нь төрийн захиргааны албан хаагч байж болно.	222	Тухайлсан санал байхгүй боловч 222 иргэн дэмжсэн

Олон нийтийн хэлэлцүүлгийн саналыг хавсрагав.